Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар

# ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ

/2019 оны жилийн эцсийн байдлаар/

2019.12.13 Улаанбаатар хот

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Гарсан үр дүн | Үнэлгээний хувь | Хяналтаас гаргах тухай санал дүгнэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Засгийн газрын тогтоол** | | | | | | |
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | 1.1 | Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх | Тайлант хугацаанд газрын даргын 2018 оны “Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх тухай” А/27 дугаар тушаалын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилласнаар ёс зүйн болон сахилгын зөрчлийн тоо өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.<br>Мөн ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, ажлаас хоцорсон болон эрт тарсан ажилтан, албан хаагчдад хариуцлага тооцон ажиллаж байна. Ажилтан албан хаагчдын ур чадварыг үнэлэхдээ сануулах | 2018 онд 17 ажилтан ёс зүйн зөрчил гаргасан бол 2019 онд 11 ёс зүйн зөрчил бүртгэгдэж, өмнөх оноос 35,3 хувиар буурч, сахилга хариуцлага сайжирсан.<br>Ажлаас хоцрох, эрт тарах зөрчил оны эхэнд 0.11, оны сүүлд 0,03 коэфицент болж буурсан байна. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | | | хуудас авсан байдлыг тооцон үнэлж, цаг ашиглалтын тухай мэдээллийг ажилтан албан хаагчдад тогтмол мэдээллэж ажилласан. | | | |
| | 1.2 | Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 210 өргөдөл ирснээс 209 өргөдлийг шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд биечлэн хүргүүлсэн ба 1 өргөдөл судлагдах шатанд байна. Бүтэн жилийн байдлаар өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил бүртгэгдсэн. | Өргөдөл гомдлын хандалт 2018 онд 234 байсан бол энэ оны жилийн эцсийн байдлаар 210 өргөдөл бүртгэгдэж 10.2%-иар зөрчлийн тоо өмнөх онд 62 байсан бол энэ онд 2 болж 96.7 хувиар буурсан байна.<br>Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2018 онд 6445 минут байсан бол 2019 онд 5184 минут болж, өмнөх оноос 19.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100% | - |
| | 1.3 | Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах | “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 3.1.1, “Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө”-ний 1.1.1-д заасны дагуу ажлын байранд хяналт шинжилгээ хийж, газрын даргын 2019 оны А/24 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн | Ажлын байранд хийсэн хяналт шинжилгээний дүнд нийт 53 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажилтан, албан хаагч бүр албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд дагуу ажил үүргээ давхардал чирэгдэлгүй | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | | | боловсруулж, Төрийн албаны зөвлөлд танилцуулж, санал авсан. Мөн газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын байрны шинжилгээ хийж, дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан болно. | гүйцэтгэж байна. | | |
| | 1.4 | Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж буй бөгөөд тайлант хугацаанд дараах албан хаагчдыг дэвшүүлэн ажиллуулсан байна. Хүний нөөцийн менежер Г.Энхтуяаг захиргааны ахлах мэргэжилтнээр, байр хариуцсан менежер М.Алтантуяаг үйлчилгээний албаны даргаар, цахилгаанчин Б.Батсүрэнг цахилгааны инженерээр, үйлчлэгч Г.Мөнхцэцэгийг зоогийн газрын кассаар, хурлын заалны зохион байгуулагч Ц.Үрэлмааг дотоод ажил, сургалт хариуцсан ажилтнаар, тооцооны нягтлан бодогч П.Ариунцэцэгийг ахлах нягтлан бодогчоор тус тус дэвшүүлэн ажиллаж байна. | Тайлант хугацаанд 6 албан хаагчийг албан тушаал дэвшүүлэн ажиллуулсан ба энэхүү ажлын үр дүнд ажилтан, албан хаагчид идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах сэдэл бүрдэж буй нь 2018 онд өөрийн санаачилгаар 64 ажилтан, албан хаагч ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан бол 2019 онд энэ үзүүлэлт 37 болж, өмнөх оны мөн үеэс 57,8 хувиар буурсан байна. | 100% | - |
| | 1.5 | Төрийн захиргааны болон | Манай байгууллага нь Төрийн албаны | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | | төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалныг томилох | тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамаарах бөгөөд төрийн албыг түр орлон гүйцэтгэж буй орон тоо байхгүй болно. | - | - | Хяналтаас хасуулах саналтай. |
| | 1.6 | Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх | Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа 12 ажилтан албан хаагч, эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 1 албан хаагч, нийт 14 ажилтан албан хаагчийн ажлын байрны сул тоонд мөн тооны ажилтан, албан хаагчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/819 дүгээр захирамжын дагуу Баянхошуу дэд төвийн ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллаж буй гэрээт ажилтныг орон тоондоо нэмэгдүүлэн багтаах асуудлыг эрх бүхий байгууллагад уламжилж, орон тоог 2020 оноос нэмэгдүүлэх болсноор | Тайлант хугацаанд түр орон тоонд гэрээт ажилтан ажиллуулаагүй байна. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | | | Баянхошуу дэд төвийн ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг мөн оноос үндсэн ажилтнаар шилжүүлэн ажиллуулна. | | | |
| | 1.7 | Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэмд сахилга хариуцлагыг сайжруулах талаар нэмэлт заалт тусгаж, гаргасан. Тайлант хугацаанд ажлын байранд архидан согтуурсан 2 удаагийн зөрчил гарсан ба газрын даргын тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. | 2019 оны сүүлийн улирлад энэ төрлийн зөрчил гараагүй | 100% | - |
| | 1.8 | Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах | Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай ажлууд хэрэгжүүлж, ёс зүйн зөрчлийн сургалт 2 удаа, харилцаа хандлагын чиглэлээр 3 сургалт зохион | Сургалт, нийгмийн ажлын үр дүнд 2018 онд 17 ажилтан ёс зүйн зөрчил гаргасан бол энэ тоо 2019 онд 11 болж, ёс зүйн зөрчлийн тоо өмнө оноос 35,3 хувиар буурсан байна. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | | | байгуулсан. | | | |
| | 1.10. | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах | Газрын хөдөлмөрийн дотоод журам болон ёс зүйн дүрэмд ажилтан, албан хаагчид бие биенээ ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан. | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгаварлан гадуурхсан үйлдлийн талаар ажилтан, албан хаагчаас огт гомдол санал ирээгүй болно. | 100% | - |
| | 3. | Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх | Тайлант хугацаанд дараах ажлуудад хяналт шинжилгээ хийсэн болно. Үүнд:<br>• 34 төрлийн ззахирамжлалын баримт бичгийн 97 заалтын хэрэгжилт улирал бүр;<br>• Байгууллагын дүрмээр хүлээсэн 7 чиг үүргийн хэрэгжилтэд улирал бүр;<br>• Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр;<br>• Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 42 заалтын хэрэгжилтэд улирал бүр;<br>• НЗДТГ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 20 заалтын хэрэгжилтэд улирал бүр;<br>• Газрын даргын өгсөн үүргийн дагуу 2018, 2019 онд холбогдох албан | Тайлант хуганцаанд нийт 26 төрлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ 104 төрлийн ажил сайжруулах зөвлөмж өгч, хэрэгжилтийн биелэлтийг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал танилцуулж ажилласан. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай | | шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | • хаагчдад хүлээлгэн өгсөн хангамжийн материал, багаж хэрэгсэлийн ашиглалтын байдалд;<br>• Байгууллагын 2019 онд явуулсан албан бичгүүд;<br>Мөн 2019 оны дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу тусгайлан хийх хяналт-шинжилгээг 8 удаа зохион байгуулж, дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. | | | |
| | 2 | Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, 2019 оны 33 дугаар тогтоолд нийцүүлэн боловсруулж, газрын даргын А/21 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. | Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын цахим хуудасд ил тодоор байршуулсан бөгөөд ажилтан, албан хаагчид хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. | 100% | - |
| **Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | | |
| | 1 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны 1-р улиралд багтаан олон нийтэд ил тод, | Манай байгууллага энэ онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулаагүй болно. | - | - | Хяналтаас хасуулах саналтай. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| 2019.01.16 № 03 – I Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | шуурхай зохион байгуулах | | | | |
| | 2 | Төрийн болон орон нутгийн удирдлагын бүх шатны баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх | Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/666 дугаар захирамжаар баталсан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмийн дагуу манай байгууллагын үйл ажиллагаа нь иргэд олон нийтэд чиглэдэггүй, нийслэлийн засаг захиргааны байруудад байрлан ажиллаж буй төрийн албан хаагчдад чиглэсэн учир энэхүү заалт нь хамааралгүй болно. | - | - | Хяналтаас хасуулах саналтай. |
| | 3 | Төрийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх | Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 210 өргөдөл ирснээс 209 өргөдлийг шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд биечлэн хүргүүлсэн ба 1 өргөдөл судлагдах шатанд байна. Бүтэн жилийн байдлаар өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил бүртгэгдсэн. | Өргөдөл гомдлын хандалт 2018 онд 234 байсан бол энэ оны жилийн эцсийн байдлаар 210 өргөдөл бүртгэгдэж 10.2%-иар, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2018 онд 6445 минут байсан бол 2019 онд 5184 минут болж, өмнөх оноос 19.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 100% | - |
| | 4 | Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар | Тайлант хугацаанд ажлын байранд архидан согтуурсан 2 зөрчил гарсан ба газрын даргын тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. | 2019 оны сүүлийн улирлад энэ төрлийн зөрчил гараагүй | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – I Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмын зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх | | | | |
| | 5 | Яам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, ажлын тайлан мэдээ, газрын хэмжээнд хэрэгжиж буй дүрэм журам, заавар стандарт, худалдан авах ажиллагааны талаарх тайлан мэдээ, урилга, хүний нөөцийн талаарх мэдээлэл, газрын даргын баталсан тушаал, зэргийг www.khangardi.mn цахим хуудсанд тухай бүр байршуулан ажиллаж байна. Тус газар нь төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд ямар нэгэн тусгай зөвшөөрөл олгодоггүй болно. | Тайлант хугацаанд байгууллагаас зохион байгуулсан, хамтран зохион байгуулсан, хамрагдсан үйл ажиллагааны талаарх 75 төрлийн мэдээ, мэдээллийг www.khangardi.mn цахим хуудсанд байршуулсан болно. Мөн байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой 4 үндсэн чиглэл бүхий 31 төрлийн мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулав. | 100% | - |
| | 6 | Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллах | “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд нийцүүлэн захиргаа, санхүүгийн хэлтсийн 45 ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр дүгнэж ажиллалаа. | Ажилтан, албан хаагчдаас ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр, ажлын дэлгэрэнгүй тайланг хагас, бүтэн жилээр гаргаж бүрэн хэвшсэн. Байгууллагын зүгээс ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг харгалзан үр | 85% | Төлөвлөгөөний биелэлтийг 2019.12.25-ны өдрийн дотор НЗДТГ-т хүргүүлэх бөгөөд хугацаа болоогүй. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – I Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | | | чадвар, мөнгөн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэж байна. | | |
| | 7 | Төрийн бүх шатны байгууллагын салбар нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох | Захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчдын ажлын бүтээмжийн үнэлгээг үндсэн 5 үзүүлэлт бүхий шалгуураар үнэлж дүгнэж байна. Харин төрийн албан хаагчидтай шууд харилцдаг үйлчилгээний болон инженер техникийн ажилтнуудын ажлын чанар, ёс зүйг үнэлж дүгнэх зорилгоор "Хяналтын хуудас" болон "Үнэлгээний карт"-ын системийг нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлж байна. | Захиргаа санхүүгийн хэлтсийн ажилтан албан хаагчдын 2019 оны ажлыг дүгнэх ажлын хэсгийг газрын даргын 2019 оны А/73 дугаар тушаалаар байгуулж, 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тайланг хамгуулуулж дүгнэсэн. | 100% | - |
| | 8 | Төрийн албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан хаагчдад заавал хариуцлага тооцож байх | Нийтлэг үйлчилгээний газрын “2019 оны сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран дараах сургалтыг зохион байгуулж, ажилтан, албан хаагчдыг хамрууллаа. Үүнд:<br>• Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар;<br>• “Төгс Баян Хүрээ” ХХК-тай хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт;<br>• Нийслэлийн цагдаагийн удирдах | Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас гэмт хэргийн шинжтэй хууль зөрчсөн үйлдэл гараагүй болно. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | | газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран тус хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Э.Баярбаясгалан “Зөрчлийн тухай хууль”-ийн талаар мэдлэг олгох сургалт. | | | |
| | 9 | Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбон дүгнэх үнэлгээний журам тогтоох | Төрийн албан хаагчидтай шууд харилцдаг үйлчилгээний болон инженер техникийн ажилтнуудын ажлын чанар, ёс зүйг үнэлж дүгнэх зорилгоор "Хяналтын хуудас" болон "Үнэлгээний карт"-ын системийг нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлж байна.<br>Түүнчлэн хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор зохион байгуулсан сэтгэл ханамжийн судалгаанд нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч оролцож, санал хүсэлтээ ирүүлсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 64% нь сайн, 28% нь дунд, 8% нь хангалтгүй үнэлгээ өгсөн. Дүнг даргын дэргэдэх зөвлөлийн 7-р хурлаар хэлэлцэж байр тус бүрд гарсан санал хүсэлтийг хэрэгжүүлж ажиллах үүргийг холбогдох албан хаагчдад өгсөн. | 2019 оны эхний хагас жилд зохион байгуулсан сэтгэл ханамжийн судалгаанд нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч оролцож, байгууллагын үйл ажиллагаанд 64% нь сайн, 28% нь дунд, 8% нь хангалтгүй үнэлгээ өгсөн бол мөн оны сүүлийн хагас жилд зохион байгуулсан “Таныг сонсъё” аянд нийт 683 ажилтан, албан хаагч оролцож байгууллагын үйл ажиллагаанд оролцогчдын 68% нь сайн, 27% дунд, 5% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна. Дүгнэхэд санал асуулгад оролцогчдын сайн үнэлгээ 4%-иар өсч, дунд үнэлгээ 1%, хангалтгүй үнэлгээ 3%-иар тус тус буурсан байна. | 100% | - |
| | 1.1 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг | “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Дотоод хяналт- | Ажлын байранд хийсэн хяналт шинжилгээний дүнд | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан ЗГХЭГ-т ирүүлэх | шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө”-ний дагуу ажлын байранд хяналт шинжилгээ хийж, нийт 53 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. | нийт 53 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажилтан, албан хаагч бүр албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд дагуу ажил үүргээ давхардал чирэгдэлгүй гүйцэтгэж байна. | | |
| 2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | 1.2 | Төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах | Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж буй бөгөөд тайлант хугацаанд дараах албан хаагчдыг дэвшүүлэн ажиллуулсан байна. хүний нөөцийн менежер Г.Энхтуяаг захиргааны ахлах мэргэжилтнээр, байр хариуцсан менежер М.Алтантуяаг үйлчилгээний албаны даргаар, цахилгаанчин Б.Батсүрэнг цахилгааны инженерээр, үйлчлэгч Г.Мөнхцэцэгийг зоогийн газрын кассаар, хурлын заалны зохион | Тайлант хугацаанд 6 албан хаагчийг албан тушаал дэвшүүлэн ажиллуулсан ба энэхүү ажлын үр дүнд ажилтан, албан хаагчид идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах сэдэл бүрдэж буй нь 2018 онд өөрийн санаачилгаар 64 ажилтан, албан хаагч ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан бол 2019 онд энэ үзүүлэлт 37 болж, өмнөх оны мөн үеэс 57,8 хувиар буурсан байна. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | | байгуулагч Ц.Үрэлмааг дотоод ажил, сургалт хариуцсан ажилтнаар, тооцооны нягтлан бодогч П.Ариунцэцэгийг ахлах нягтлан бодогчоор тус тус дэвшүүлэн ажиллаж байна. | | | |
| | 1.3 | Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан тушаалтнуудыг зохих журмын дагуу томилох, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, дүнг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗГХЭГ-т ирүүлэх | Манай байгууллага нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан үйлчилгээний албан хаагчийн ангилалд хамаарах тул энэхүү заалт нь хамааралгүй болно. | - | - | Хяналтаас хасуулах саналтай. |
| | 1.4 | Төрийн захиргааны албан тушаалын байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж хууль тогтоомж зөрчдөг үйлдлийг таслан зогсоох, ийм гэрээт ажилтны гэрээг цуцалж, уг орон тоог хуульд заасан журмын дагуу нөхөх | Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/819 дүгээр захирамжийн дагуу Баянхошуу дэд төвийн ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллах 10 ажлын байранд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дуустал гэрээт ажилтан томилон ажиллуулж байна. | Баянхошуу дэд төвийн ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах ажиллагчдыг байгууллагын батлагдсан орон тоонд нэмэгдүүлэн багтаах асуудлыг эрх бүхий байгууллагад уламжилж, орон тоог 2020 оноос нэмэгдүүлэх болсноор Баянхошуу дэд | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | | | төвийн ашиглалт үйлчилгээг хариуцан ажиллаж буй ажиллагсдыг мөн оноос үндсэн ажилтнаар шилжүүлэн ажиллуулна. | | |
| | 1.5 | Төрийн захиргааны байгууллагын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэх | Ажилтан, албан хаагчдын хэрэглэж буй компьютер, техник хэрэгслийн элэгдлийг холбогдох журмын дагуу тооцон, актлах хугацаа болсон хөрөнгийг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрээр акталсан тохиолдолд тэдгээрийг шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттай хэрэгжүүлж ажиллалаа. | Ажилтан, албан хаагчдын ажлын техник хэрэгслийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан шинэчлэх ажлыг үе шаттай хийснээр захиргаа, санхүүгийн хэлтсийн нийт албан хаагчид ажлын компьютер, принтерээр бүрэн хангасан. | 100% | - |
| | 1.6. | Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсний үндсэн дээр боломжит үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаа, сургалт мэдээллийн цаг, оролцсон, хамрагдсан, хамтран ажилласан арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр зурагжуулан баримтжуулж, холбогдох мэдээллийн хамт www.khangardi.mn цахим хуудсанд байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 75 төрлийн мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулжээ. | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулж ажилласнаар нийслэлийн нийтлэг үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг нийтэд сурталчилж, ид тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж байна. | 100% | - |
| | 1.7. | Төрийн албаны хүний нөөцийн асуудал хариуцсан | Батлагдсан төлөвлөгөөний дагуу хүний нөөцийн асуудал хариуцсан | Хүний нөөцийн ажилтны мэргэжлийн ур чадварыг | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | мэргэжилтнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах | ажилтныг дараах сургалтуудад хамрууллаа. Үүнд:<br>• “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар;<br>• Баримт бичиг боловсруулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар;<br>• Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр<br>Монгол хэлний зөв бичих дүрмийн тухай. | дээшлүүлэх үүднээс 2019 онд 4 төрлийн сургалтад хамруулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 дахин өссөн зэрэг үзүүлэлтийг харуулж байна. | | |
| | 1.8. | Төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан төлөвлөх, албан хаагчдыг сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлага, үр дүн нь тодорхой бус сургалтад оролцуулахаас татгалзах | “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдад чиглэсэн 21 төрлийн сургалтыг зохион байгуулсан.<br>Байгууллагын сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хүрээнд тайлант хугацаанд мэргэжлийн 13, ажлын туршлага солилцуулах 2, харилцаа хандлага, ёс зүй, ажлын цаг ашиглалттай холбоотой 6, нийт 21 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 497 ажилтан, албан хаагчийг хамруулжээ. | Байгууллагын санаачилгаар 2018 онд 18 сургалт зохион байгуулж байсан бол энэ онд 21 сургалт зохион байгуулж сургалтын тоо 16.6 хувиар, хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо 2018 онд 400, 2019 онд 497 болж 24.2 хувиар тус тус өссөн байна. | 100% | - |
| | 1.9. | Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны | Ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай | | дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх | тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн үнэлж, цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг шийдвэрлэж байна. Ажилтан, албан хаагчдын ажлын үнэлгээг улирал бүр байгууллагын www.khangardi.mn цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж буй болно. | хэрэгжилтийн мэдээг ажилтан албан хаагч бүрт танилцуулах үүднээс цахим хуудсанд хагас, бүтэн жилээр байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын үр дүнд албан хаагч бүр байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх | | |
| | 1.10. | Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт шинжилгээ хийж үр дүнг албан хаагчдад тогтмол мэдээлж байх | “Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж дүнг 2019.06.20-ны өдөр даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Харин байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэн жилийн хэрэгжилтийг дүгнэх үүднээс ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргуулж, 2019.12.12-ны өдөр Захиргаа, санхүүгийн хэлстийн албан хаагч тус бүрээр тайланг хэлэлцүүлж дүгнэсэн. Ажлын тайлангийн нэгдсэн дүнг 2019.12.13-ны өдөр даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан болно. Байгууллагын төлөвлөгөөний | төлөвлөгөөний талаар мэдээлэл авч, түүнд нийцүүлэн өөрийн хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөж байгууллага-албан хаагчийн ажлын харилцан уялдаа холбоо сайжирсан. | 100% | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1.11. | Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэн байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож, иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, хэвшүүлэх | Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцүүлэн төрийн албыг төлөвшүүлэх, сахилга хариуцлагыг сайжруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны байруудын ашиглалт, цэвэрлэгээ үйлчилгээ, зоогийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сэтгэл ханамжийг хүртээмжтэй, үнэн бодит байдлаар хүлээн авах боломжийг эрэлхийлэн 2018 оноос эхлэн "Таныг сонсоё" аяныг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. | "Таныг сонсъё" аяныг энэ онд шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, аянд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбаруудын 683 ажилтан, албан хаагч оролцож санал хүсэлтээ илэрхийлсэн ба манай байгууллагын үйл ажиллагаанд санал асуулгад оролцогчдын 68% нь сайн, 27% дунд, 5% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна. | 100% | - |
| **Засгийн газрын албан даалгавар** | | | | | | |
| Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэл-тийг хангуулах зарим арга хэмжээний тухай 2019.08.08 №2019_01 | 2 | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулиар өөрийн эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарын хэмжээнд батлагдсан төсөл, арга хэмжээний ач холбогдол, явц байдал, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж, нээлттэй өдөрлөг, | Манай байгууллага энэ онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулаагүй болно. Харин урсгал зардлын хөрөнгөөр нийслэлийн засаг захиргааны байруудад хийсэн засвар тохижилт, засан сайжруулалтын ажлын тухай мэдээ мэдээллийг тухай бүр байгууллагын www.khangardi.mn цахим хуудсанд байршуулж ажиллалаа. | Урсгал зардлын хөрөнгөөр 2019 онд хийсэн засвар тохижилт, засан сайжруулалтын ажлын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж ажилласнаар худалдан авах ажиллагааны болон байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан | 100% | - |

| 1 | 2 | 3 | · 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | танилцуулгыг үе шаттайгаар нэгдсэн болон тусгайлсан хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд сурталчилан ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга нарт | | байна. | | |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ШИНЭЧИМЭГ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ҮНЭЛСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН Т.ИТГЭЛ

ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭГ НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН Э.ХОРОЛДУЛАМ